

Монгол Улсын Их Хурлын Хууль
зүйн байнгын хорооны 2026 оны ...
дугаар сарын ... -ны өдрийн
дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ШҮҮГЧ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИХ ТУХАЙ ХҮСЭЛТ

Товч удирдамж: Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвших тухай хүсэлт гаргахдаа энэхүү загварт асуусан асуулт, шаардсан мэдээлэл бүрийн доор /ард/ хариултаа үнэн зөв, бүрэн дүүрэн бичнэ. Компьютерын программ ашиглаж бичсэн хүсэлтийг цаасаар хэвлэж гарын үсэг зурах бөгөөд уг эх хувь, түүний хавсралтыг Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд хүргүүлнэ. Мөн нэр дэвших тухай хүсэлтийг Word-ын файлаар цахим шуудан /сонгон шалгаруулах тухай зард заасан хаяг/-аар тус Байнгын хороонд явуулна.

НЭГ. ХҮСЭЛТ ГАРГАГЧИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА:

1.1	Эцэг/эхийн нэр: Ганзориг Ургийн овог: Буурлууд Нэр: Эрдэнэбулган Хүйс: эр Төрсөн он: 1986 Төрсөн газар: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 2 дугаар төрөх эмнэлэг Одоо оршин суугаа аймаг/нийслэл, сум/дүүрэг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
1.2	Иргэний харьяалал Монгол Улсын иргэн мөн үү /тийм, эсхүл үгүй гэж бичих/. Тийм. Иргэний үнэмлэхийн хуулбар хавсаргав.
1.3	Насны дээд хязгаар Төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн үү /тийм, эсхүл үгүй гэж бичих/. Үгүй. Нас 40. Иргэний үнэмлэхийн хуулбар хавсаргав.
1.4	Шүүгчийн албан тушаал Шүүгчээр ажиллаж байгаа юу, эсхүл ажиллаж байсан уу /тийм, эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, аль шүүхэд ямар хугацаанд шүүгчээр ажиллаж байгаа, эсхүл байсан талаараа хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/. Үгүй.
1.5	Улс төрийн болон намын удирдах албан тушаал Сүүлийн таван жил улс төрийн албан тушаал болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байгаа юу, эсхүл эрхэлж байсан уу /тийм, эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, ямар албан тушаалыг ямар хугацаанд эрхэлж байгаа, эсхүл эрхэлж байсан талаараа хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/. Үгүй
1.6	Эрүүгийн хариуцлага

	Эрүүгийн хариуцлага хүлээж байсан уу /тийм, эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.
	Үгүй
1.7	Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээр ажиллаж байгаа юу, эсхүл ажиллаж байсан уу /тийм, эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, уг албан тушаалыг ямар хугацаанд эрхэлж байгаа, эсхүл байсан талаараа хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.
	Үгүй
1.8	Монгол Улсын Их Хурлаас Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнээр томилохоос татгалзаж байсан Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшсэн боловч Монгол Улсын Их Хурлаас томилохоос татгалзаж байсан уу /тийм, эсхүл үгүй гэж бичих/.
	Үгүй

ХОЁР.ХИЙХ АЖИЛ, НЭР ДЭВШСЭН ҮНДЭСЛЭЛЭЭ БИЧСЭН ТАЙЛБАР

2.1	<p>Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүний хувьд хийх ажил, уг албан тушаалд нэр дэвшсэн үндэслэлээ тайлбарлаж тодорхой, ойлгомжтой бичнэ /тайлбарыг 500-1000 үгэнд багтаана/</p> <p>Миний бие өөрийн эзэмшсэн мэргэжил, хууль зүйн салбарт ажилласан туршлага, мэдлэг, чадвартаа үндэслэн Монгол Улсын шүүх эрх мэдлийн хөгжилд хувь нэмэр оруулах чин хүсэл эрмэлзэлтэйгээр Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэрээ дэвшүүлж байна.</p> <p>Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар Шүүхийн ерөнхий зөвлөл нь шүүх, шүүгчийн шүүн таслах ажиллагаанд оролцохгүйгээр, гагцхүү хуульчдаас шүүгчийг шилж олох, эрх ашгийг нь хамгаалах, шүүхийг бие даан ажиллах нөхцөлөөр хангах үндсэн чиг үүрэгтэй. Энэхүү хариуцлагатай үүргийг хэрэгжүүлэхэд шүүгч бус гишүүн нь шүүх засаглалд олон нийтийн хяналт, мэргэжлийн тэнцвэрийг хангах чухал хөшүүрэг болно гэж бодож байна.</p> <p>Монгол Улсын шүүхийн тухай хуульд Шүүхийн ерөнхий зөвлөлийн хэрэгжүүлэх чиг үүргийг заасан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах; - Хүний нөөцийн чадавх ба шүүгчийг шилж олох ажиллагаа; - Шүүхийн санхүү, эдийн засгийн баталгааг бэхжүүлэх; - Мэдээллийн ил тод байдлыг хангах. <p>Монгол Улсын Их Хурлын 2024 оны 33 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлого”-ын хэрэгжилтийг тууштай хангахад хүчин чармайлт гаргаж, үр дүнд хүрэх нь зүйтэй юм.</p> <p>Иймд Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшигчийн хувьд миний үндсэн зорилго нь шүүхийн бие даасан байдал, шүүгчийн хараат бус</p>
-----	---

	<p>байдлыг институцийн түвшинд бэхжүүлэх, шүүхийн захиргааны менежментийг орчин үеийн шаардлагад нийцүүлэн хөгжүүлэх, иргэдийн шүүхэд итгэх итгэлийг нэмэгдүүлэхэд чиглэнэ.</p> <p>Монгол Улсын шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлогод туссан зорилт, үйл ажиллагааг хэрэгжүүлэх хүрээнд дараах чиглэлд онцгойлон анхаарч ажиллана. Үүнд:</p> <p>Нэгдүгээрт, шүүхийн бие даасан байдлын эдийн засаг, зохион байгуулалтын баталгааг бэхжүүлэхэд анхаарна. Үүний хүрээнд шүүхийн захиргааны байгууллагын бие даасан, мэргэшсэн тогтолцоог хөгжүүлэх чиглэлээр ажиллана.</p> <p>Хоёрдугаарт, шүүхийн цахим шилжилт, мэдээллийн нээлттэй тогтолцоог хөгжүүлэхэд онцгойлон анхаарч ажиллана. Иргэн төвтэй, хүртээмжтэй шүүхийн үйлчилгээг хөгжүүлэх, шүүхийн үйл ажиллагааг цахимжуулахтай холбоотой эрх зүйн орчныг боловсронгуй болгох хүрээнд цахим шүүх, мэдээллийн нэгдсэн систем, шүүхийн статистик, шүүхийн шийдвэрийн нээлттэй санг хөгжүүлэх, хиймэл оюун ухаанд суурилсан дэвшилтэт технологийн шийдлийг үе шаттай нэвтрүүлэх бодлогыг дэмжин ажиллана.</p> <p>Гуравдугаарт, шүүхийн захиргааны хүний нөөцийн тогтолцоог чадавхжуулах чиглэлээр ажиллана. Шүүхийн захиргааны ажилтны мэргэшил, тогтвортой байдал, ёс зүй, гүйцэтгэлийн үнэлгээ, тасралтгүй сургалтын тогтолцоог боловсронгуй болгох нь шүүхийн үйлчилгээний чанарт шууд нөлөөлнө гэж үзэж байна.</p> <p>Түүнчлэн, шүүхийн үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлэх, олон нийтийн итгэлийг бэхжүүлэх, иргэдийн шүүхэд мэдүүлэх эрхийг бодитоор хангах чиглэлээр иргэний нийгэм, хуульчдын мэргэжлийн байгууллага, судлаачидтай хамтын ажиллагааг өргөжүүлэх нь зүйтэй гэж үздэг.</p> <p>Миний хувьд хууль зүйн салбарт ажилласан туршлага, төрийн бодлого боловсруулах, эрх зүйн шинэтгэлийн ажлыг удирдан зохион байгуулж ирсэн мэдлэг, ур чадвараа шүүх эрх мэдлийн институцийн хөгжил, хараат бус байдал, хариуцлагатай засаглалыг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулах зорилгоор Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшиж байна.</p>
--	--

ГУРАВ.МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАНИЛЦУУЛГА

Д/д	Шалгуур үзүүлэлт
3.1	<p>Эрх зүйч мэргэжлээр ажилласан байдал</p> <p>Хүсэлт гаргагч нь эрх зүйч мэргэжлээр ажилласан байдлын талаар хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар тодорхойлон бичих бөгөөд ажил тус бүрийг эрхэлж байсныг нотлох баримтыг хавсаргана. Ажил тус бүрийг тодорхойлохдоо дараах мэдээллийг заавал бичнэ:</p> <ul style="list-style-type: none"> -албан тушаалын нэр, ажлын газрын хаяг, ажилласан хугацаа; -ажлын байрны тодорхойлолтын гол агуулга; -удирдах албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл /утасны дугаар, цахим шуудангийн хаяг, ажлын газрын хаяг зэрэг/; -тухайн албан тушаал эрхэлж байхдаа хамтран ажиллаж байсан, өөрийн удирдлагад ажиллаж байсан, ажил хэргийн харилцаатай байсан таваас доошгүй хүний нэр /нэрс аль болох давхцахгүй байх/, холбоо барих мэдээлэл /утасны дугаар, цахим шуудангийн хаяг, ажлын газрын хаяг зэрэг/.

1. 2023.10.30 - одоог хүртэл Хууль зүй, дотоод хэргийн яаманд газрын даргаар ажиллаж байна.

2023.10-2024.11 хүртэл Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга;

2024.11-2025.11 хүртэл Хууль зүй, дотоод хэргийн яамны Сургалт, сурталчилгаа, хөтөлбөрийн хэрэгжилтийн газрын дарга;

2025.11-2026.04 хүртэл Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга

2026.04 сараас одоог хүртэл Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын даргаар тус тус ажиллаж байна.

Ажлын байрны тодорхойлолтын гол агуулга: Хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэлийг төлөвлөх, хууль тогтоомж болон Засгийн газрын шийдвэрийн төсөл боловсруулах, бодлогын удирдамж, мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр хангах, захиргааны хэм хэмжээний актын бүртгэл, хяналтыг хэрэгжүүлэх, хууль зүйн боловсрол, бүх нийтийн эрх зүйн сургалт, сурталчилгааг зохион байгуулах, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, хууль зүйн салбарын шинжлэх ухаан, инновацын бодлогын хэрэгжилтийг зохицуулах, төрийн захиргаа, хүний нөөцийн манлайллыг хангах, алба хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулах бодлого боловсруулж хэрэгжүүлэх, түүнчлэн хууль зүйн салбарын цахим бодлого, хөтөлбөрийг боловсруулах, мэдээллийн технологид суурилсан шийдлээр үйл ажиллагааг цахимжуулах, мэдээллийн аюулгүй байдал, хэвийн ажиллагааг хангах чиг үүргийг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн үр дүнг Төрийн нарийн бичгийн даргын өмнө хариуцна.

Удирдах албан тушаалтан:

- 1) 2023.11 сараас 2024.07 сар хүртэл Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр [REDACTED]
- 2) 2024.07 сараас 2025 оны 06 дугаар сарыг хүртэл Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл [REDACTED]
- 3) 2025.06-2025.10 сарыг хүртэл Хууль зүй, дотоод хэргийн сайд Л.Мөнхбаатар (утас:);
- 4) 2025.10 сараас 2026 оны 04 дүгээр сарыг хүртэл Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр [REDACTED]
- 5) 2026.04 сараас одоог хүртэл Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Амарсайхан [REDACTED]
- 6) Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд Д.Мөнх-Эрдэнэ (утас: [REDACTED])
- 7) Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга асан Н.Мягмар ([REDACTED]) нар ажиллаж байсан.

Хамтран ажилаж байсан хүмүүс:

- 1) Академич С.Нарангэрэл ([REDACTED])
- 2) Шинжлэх ухааны доктор, проф Н.Лүндэндорж ([REDACTED])
- 3) МУИС-ийн Хууль зүйн сургуулийн захирал, Проф.Др. Б.Амарсанаа ([REDACTED])
- 4) МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, Дэд проф.Др. Т.Золбоо [REDACTED]
- 5) Монголын Хуульчдын холбооны ерөнхийлөгч М.Мөнхбат (утас: [REDACTED])

6) Хууль зүйн клиник сургалтын Ахиц нийгэмлэгийн тэргүүн Д.Туяа ([REDACTED])

Удирдлагад ажиллаж байсан хүмүүс:

- 1) Захиргааны хэм хэмжээний актын хяналт, бүртгэлийн хэлтсийн дарга Ш.Цолмон ([REDACTED])
- 2) Хувийн эрх зүйн хэлтсийн дарга О.Оюунзул ([REDACTED])
- 3) Нийтийн эрх зүйн хэлтсийн дарга Д.Энхтөр ([REDACTED])
- 4) Ахлах шинжээч Д.Баясгалан ([REDACTED])
- 5) Ахлах шинжээч Ж.Амгалан ([REDACTED])
- 6) Ахлах шинжээч Т.Зул ([REDACTED])
- 7) Шинжээч Ч.Нямцэцэг ([REDACTED])
- 8) Шинжээч Б.Энхбат ([REDACTED])
- 9) Ахлах мэргэжилтэн Ц.Бадам-Очир ([REDACTED])

Ажил хэргийн харилцаатай байсан:

- 1) Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга, Др. Д.Сүнжид (утас: [REDACTED])
- 2) Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Салбарын бодлого, зохицуулалтын газрын дарга Ш.Мөнхцэрэн ([REDACTED])
- 3) Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн, Др. Ч.Хосбаяр ([REDACTED])
- 4) Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын шүүгч Б.Батцэрэн ([REDACTED])
- 5) Улсын дээд шүүхийн Иргэний хэргийн танхимын тэргүүн Др. Ч.Баярмаа ([REDACTED])
- 6) Улсын дээд шүүхийн дэргэдэх Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академийн захирал, Др. Д.Эрдэнэчимэг ([REDACTED])
- 7) Монголын Хуульчдын холбооны Ерөнхийлөгч М.Мөнхбат (утас: [REDACTED])

2.2022.06-2023.10 сарыг хүртэл “Ханхөгшин интернэшнл” ХХК-ийн Үйл ажиллагаа хариуцсан захирал

Ажлын байрны тодорхойлолтын гол агуулга: Компанийн өдөр тутмын үйл ажиллагааны хэвийн, тасралтгүй ажиллагааг хангах, дотоод хяналтыг хэрэгжүүлэх, байгууллагын соёл, алсын хараа, үнэт зүйлийг үйл ажиллагаандаа төлөвшүүлэн хэрэгжүүлэх, иргэн, хуулийн этгээд болон төр, хууль хяналтын байгууллагын өмнө компанийг төлөөлөх, хууль эрх зүй, хүний нөөц, зохицуулалтын үйл ажиллагаанд удирдлага, арга зүйн дэмжлэг үзүүлэх, холбогдох чиг үүргийн хэрэгжилт, үр дүнг Гүйцэтгэх захирлын өмнө хариуцах.

- 1) Гүйцэтгэх захирал Ц.Батмөнх ([REDACTED])
- 2) Дэд захирал Э.Анар ([REDACTED])
- 3) Хуулийн зөвлөх Г.Баасанжаргал ([REDACTED])
- 4) Барилгын төсөл хариуцсан захирал Ж.Дамдинсүрэн (утас: [REDACTED])
- 5) Барилгын ашиглалтын үйл ажиллагаа хариуцсан захирал Л.Энхбат ([REDACTED])

3.2015.05-2022.01, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газарт Засгийн газрын референт

Ажлын байрны тодорхойлолтын гол агуулга: Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн төсөл боловсруулах, хянах, Ерөнхий сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын удирдлагад үйл ажиллагааны тасралтгүй, шуурхай байдлыг хангахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, Засгийн газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрыг хууль хяналтын байгууллагад итгэмжлэлээр төлөөлөх, төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагад чиг үүргийн дагуу мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэгээр хангах чиг үүргийг хариуцна.

- 1) Засгийн газрын Тэргүүн дэд даргаар ажиллаж байсан Ш.Солонго ([REDACTED])
- 2) Хууль, эрх зүйн газрын даргаар ажиллаж байсан Д.Мөнх-Эрдэнэ ([REDACTED])
- 3) Хууль, эрх зүйн газрын даргаар ажиллаж байсан Б.Доньжчимбуу ([REDACTED])
- 4) Хууль, эрх зүйн газрын даргаар ажиллаж байсан Н.Мягмар (утас: [REDACTED])
- 5) ЗГХЭГ-ын Хууль, эрх зүйн газрын Засгийн газрын референт О.Дөлгөөнтуул ([REDACTED])
- 6) ЗГХЭГ-ын Хууль, эрх зүйн газрын Ахлах шинжээч Г.Дөлгөөн (утас: [REDACTED])
- 7) ЗГХЭГ-ын Архив, нууц, албан хэрэг хөтлөлтийн хэлтсийн дарга Д.Болор-Эрдэнэ ([REDACTED])

4.2013.05-2015.01 хүртэл Барилга, хот байгуулалтын яамны Төрийн захиргааны удирдлагын газарт Хуулийн хэлтсийн дарга

Ажлын байрны тодорхойлолтын гол агуулга: Яамны удирдлага, аппаратад хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, үүрэг даалгаврыг хэрэгжүүлэхэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, хууль тогтоомж, Засгийн газрын болон сайд, Төрийн нарийн бичгийн даргын шийдвэрийн төсөл боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх чиг үүргийг хариуцан хэрэгжүүлнэ.

- 1) Барилга, хот байгуулалтын сайдаар ажиллаж байсан Ц.Баярсайхан ([REDACTED])
- 2) Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргаар ажиллаж байсан Р.Эрдэнэбүрэн ([REDACTED])
- 3) Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн даргаар ажиллаж байсан Б.Мэндбаяр (у [REDACTED])
- 4) Барилга, хот байгуулалтын яамны Төрийн захиргааны удирдлагын газрын даргаар ажиллаж байсан Д.Баярсайхан ([REDACTED])
- 5) Барилга, хот байгуулалтын яамны Ахлах мэргэжилтнээр ажиллаж байсан Н.Билэгсайхан ([REDACTED])

5.2010.06-2013.05 хүртэл “Таван богд трейд” ХХК-ийн Хууль, эрх зүйн албанд Хуулийн мэргэжилтэн, Хуулийн зөвлөх

Ажлын байрны тодорхойлолтын гол агуулга: Компанийн үйл ажиллагаанд мөрдөх дүрэм, журам, тушаалын төсөл бэлтгэх, иргэн, хуулийн этгээдтэй байгуулах гэрээний төсөл боловсруулах, компанийг шүүх, хууль хяналтын байгууллагад итгэмжлэлээр төлөөлөх, компанийн удирдлага, ажилтанд хууль, эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх чиг үүргийг хариуцна.

	<ol style="list-style-type: none"> 1) Хууль, эрх зүйн албаны даргаар ажиллаж байсан Ч.Баярмаа (утас: [REDACTED]) 2) Хуулийн зөвлөхөөр ажиллаж байсан Г.Нямсүрэн ([REDACTED]) 3) Хуульчаар ажиллаж байсан С.Уранмандах ([REDACTED]) 4) Брэнд менежерээр ажиллаж байсан Т.Уранжаргал (утас: [REDACTED]) 5) Мэдээллийн технологийн ахлах инженерээр ажиллаж байсан Б.Ууганбаатар ([REDACTED]) <p>6.2009.06-2010.06 хүртэл “Нью прогресс групп” ХХК-ийн Захирлын ажлын албанд Хуулийн мэргэжилтэн</p> <p>Ажлын байрны тодорхойлолтын гол агуулга: Компанийн үйл ажиллагаанд мөрдөх дүрэм, журам, тушаалын төсөл бэлтгэх, иргэн, хуулийн этгээдтэй байгуулах гэрээний төсөл боловсруулах, компанийг шүүх, хууль хяналтын байгууллагад итгэмжлэлээр төлөөлөх, компанийн удирдлага, ажилтанд хууль, эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх чиг үүргийг хариуцна.</p> <ol style="list-style-type: none"> 1) Ерөнхий захирал С.Балжинням 2) Хуулийн зөвлөх С.Баянчулуун (утас: [REDACTED]) 3) Захирлын туслах Н.Баасанжаргал 4) Ерөнхий нягтлан бодогч Н.Өлзийхутаг
3.2	<p>Эрх зүйчээс бусад мэргэжлээр эрхэлсэн ажил</p> <p>Их, дээд сургууль төгссөнөөс хойш эрх зүйчээс бусад мэргэжлээр эрхэлсэн ажлыг тодорхойлон бичнэ. Ингэхдээ ажилласан байгууллагыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар жагсаах бөгөөд ажил олгогч /эсхүл удирдах албан тушаалтан/-ийн нэр, хаяг, утасны дугаар, цахим шуудангийн хаяг, цахим хуудас болон ажлын байрны нэрийг бичнэ.</p> <p>Эрх зүйчээс бусад мэргэжлээр ажиллаж байгаагүй.</p>
3.3	<p>Мэргэжлийн холбоо, байгууллагын гишүүнчлэлийн талаар</p> <p>Монголын Хуульчдын холбоо, Монголын Өмгөөлөгчдийн холбоо, хууль зүйн, эсхүл хүний эрхийн чиглэлээр ажилладаг бусад холбоо, байгууллагын гишүүн бол хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар нэрлэн бичиж, гишүүнчлэл тус бүрийг нотлох баримтыг хавсаргана.</p> <p>-Мэргэжлийн холбоо, байгууллагын гишүүн болсон огноог бичнэ. Уг байгууллагын гишүүнчлэлийг түдгэлзүүлж, хүчингүй болгож, дуусгавар болгож байсан бол энэ талаар бичиж, шалтгааныг нь тайлбарлана.</p> <p>-Мэргэжлийн холбоо, байгууллагад эрхэлж байсан албан тушаал, гүйцэтгэсэн чиг үүргийн нэр, огноог хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичнэ.</p> <p>2015 оноос одоог хүртэл Монголын Хуульчдын холбооны гишүүн, хуульч (Гэрчилгээ №4869).</p>

ДӨРӨВ.ХУУЛЬ ЗҮЙН ӨНДӨР МЭРГЭШИЛ

4.1	<p>Хууль зүйн өндөр мэргэшил</p> <p>Хүсэлт гаргагчийг хууль зүйн өндөр мэргэшилтэй /хууль зүйн өндөр мэдлэг, чадвар, туршлагатай, мэргэжлийн өндөр ёс зүйтэй/ гэдгийг нотлон харуулах хамгийн чухал 10 мэргэжлийн үйл ажиллагааг хамгийн сүүлийнхээс нь эхлэн</p>
-----	--

он дарааллаар бичиж, тодорхойлох бөгөөд үйл ажиллагаа тус бүрийг явуулсныг нотлох баримтыг хавсаргана. Ийм үйл ажиллагаа тус бүрийн талаар дараах мэдээллийг заавал бичнэ:

-үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа;

-үйл ажиллагааны гол агуулга;

-үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ;

-үйл ажиллагааг удирдсан албан тушаалтны нэр /нэрс аль болох давхцахгүй байх/, холбоо барих мэдээлэл /утасны дугаар, цахим шуудангийн хаяг, ажлын газрын хаяг зэрэг/;

-тухайн үйл ажиллагааны хүрээнд хамтран ажиллаж байсан, өөрийн удирдлагад ажиллаж байсан, ажил хэргийн харилцаатай байсан гурваас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл /утасны дугаар, цахим шуудангийн хаяг, ажлын газрын хаяг зэрэг/;

-хэвлэгдсэн бол эх сурвалжийн ишлэл, түүний хуулбар.

Нэг.Хууль зүй, дотоод хэргийн яам - Хууль зүйн бодлогын газрын дарга

1.Шүүх байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, батлуулах ажилд оролцов.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлж шүүхийн шатлалын үндсэн тогтолцоог хөндөхгүйгээр шүүхийн харьяалал, байрших газар, зохион байгуулалтыг өөрчлөх замаар иргэний шүүхэд хандах эрхийн баталгааг хангах, иргэнд үзүүлэх шүүхийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэхэд чиглэсэн бүтээмжтэй, үр нөлөөтэй анхан болон давж заалдах шатны шүүх байгуулах зорилгоор боловсруулж, өргөн мэдүүлсэн Шүүх байгуулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлаас 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр баталсан;

Удирдсан албан тушаалтан:

Хууль зүй, дотоод хэргийн сайд асан Б.Энхбаяр ([REDACTED]);

УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар ([REDACTED])

Хамтран ажилласан:

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга: ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газрын Ахлах шинжээч Ш.Цолмон ([REDACTED]);

УИХ-ын Хууль зүй байнгын хорооны зөвлөх Б.Төгсцэнгэл / [REDACTED] /;

Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын шүүгч Б.Батцэрэн (утас: [REDACTED]);

Улсын дээд шүүхийн Иргэний хэргийн танхимын тэргүүн Ч.Баярмаа (утас: [REDACTED]);

Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын тэргүүн Д.Мөнхтуяа / [REDACTED]);

Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Л.Энхбилэг / [REDACTED]);

Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Н.Отгончимэг /утас: .../

Холбогдох линк: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17140721145671>

2.“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө” /2024-2030/-г батлуулах ажилд оролцов.

Улсын Их Хурлын 2023 оны 59 дүгээр тогтоолоор баталсан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төслийг холбогдох эрх бүхий байгууллагуудтай хамтран хариуцан боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн өргөн мэдүүлсний дагуу Улсын Их Хурлын 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 46 дугаар тогтоолоор “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г баталсан болно.

Удирдсан албан тушаалтан:

Хууль зүй, дотоод хэргийн сайд асан Б.Энхбаяр ([REDACTED])
УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар ([REDACTED])

Хамтран ажилласан:

Ажлын хэсгийн ахлагч: Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд Б.Солонгоо / [REDACTED]

Ажлын хэсгийн Нарийн бичгийн дарга: ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газрын мэргэжилтэн М.Ганбагана /утас [REDACTED]

Авлигатай тэмцэх газрын Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хэлтсийн дарга М.Даваатогтох / [REDACTED]

Авлигатай тэмцэх газрын Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хэлтсийн албаны дарга Д.Дуламсүрэн / [REDACTED]

Авлигатай тэмцэх газрын Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хэлтсийн албаны дарга Ц.Шинэбаяр /утас: /;

Авлигатай тэмцэх газрын Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хэлтсийн албаны дарга Л.Сүх-Очир [REDACTED]

Үзэх линк: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17140736526681>

3.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн төслийг боловсруулах ажилд оролцов.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023.11.09-ний өдрийн А/386 дугаар тушаалаар дээрх хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан бөгөөд Ажлын хэсгээс хуулийн шинэчилсэн найруулгын төслийг эцэслэн боловсруулж бэлэн болгосон.

Улмаар уг хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Улсын Их Хуралд 2026 оны 03 дугаар сарын 18-ны өдөр өргөн мэдүүлсэн.

Удирдсан албан тушаалтан:

Хууль зүй, дотоод хэргийн сайд асан Б.Энхбаяр ([REDACTED]);
УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар ([REDACTED])

Хамтран ажилласан:

Ажлын хэсгийн ахлагч: Хууль зүй, дотоод хэргийн сайдын зөвлөх асан Д.Мөнх-Эрдэнэ /утас [REDACTED]

Ажлын хэсгийн Нарийн бичгийн дарга: ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газрын Шинжээч Ж.Амгалан /утас [REDACTED]

Ажлын хэсгийн нэр бүхий гишүүд /Ажлын хэсгийн тушаалыг хавсаргав/

Үзэх линк: <https://d.parliament.mn/tusul/d7a82659-b7a2-4d40-99f6-6f01296c3fed>

4.Хүний эрхийг хангах чиглэлээр багц хуулийн төслийг боловсруулав.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023.11.09-ний өдрийн А/387 дугаар тушаалаар хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, үндэсний хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хүний эрхийн олон улсын гэрээ конвенцод нийцүүлэх зорилгоор дараах хууль тогтоомжийг төслийг боловсруулсан. Үүнд:

-Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;

-Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;

-Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /11 хуулийн төсөл/.

Улмаар тус яамнаас эцэслэн боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар

хэлэлцүүлэн Улсын Их Хуралд 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр өргөн мэдүүлсэн.

Удирдсан албан тушаалтан:

Хууль зүй, дотоод хэргийн сайд асан Б.Энхбаяр (■■■■■■■■■■);
Хууль зүй, дотоод хэргийн сайд асан О.Алтангэрэл (■■■■■■■■■■);
Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар /утас: ■■■■■■

УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар (утас: 99119172)

Хамтран ажилласан:

Ажлын хэсгийн Нарийн бичгийн дарга: ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газрын Шинжээч Т.Нарантунгалаг /утас: /; Шинжээч Б.Алтантуяа /утас:/
Ахмалах мэргэжилтэн О.Мандах /утас:/
Ажлын хэсгийн нэр бүхий гишүүд /Ажлын хэсгийн тушаалыг хавсаргав/

Үзэх линк: <https://d.parliament.mn/tusul/40e9e98f-543e-4580-9b00-195d0f263ec0>

<https://d.parliament.mn/tusul/d61259be-fafe-414c-923b-e980aa129a2e>

<https://d.parliament.mn/tusul/592cd558-7c3b-4afc-bb78-ff366f3f6c10>

5.Шүүн таслах үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлын эрх зүйн орчныг боловсронгуй болгох ажилд оролцов.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2024.04.05-ны өдрийн А/97 дугаар тушаалаар шүүн таслах үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг сайжруулах, шүүх хуралдааныг цахимаар нэвтрүүлэх болон шүүхийн цахимжилтын эрх зүйн орчныг боловсронгуй болгох үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, Ажлын хэсгээс дараах хууль тогтоомжийн төслийг боловсруулсан. Үүнд:

- Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;
- Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;
- Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;
- Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

Хуулийн төслийг УИХ-ын нэр бүхий гишүүд өргөн мэдүүлсэн нь 2024.06.05-ны өдөр эцэслэн батлагдсан.

Удирдсан албан тушаалтан:

Хууль зүй, дотоод хэргийн сайд асан Б.Энхбаяр (утас■■■■■■■■■■);
Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар /утас: 99109376/;

УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар (утас: ■■■■■■)

Хамтран ажилласан:

Ажлын хэсгийн Нарийн бичгийн дарга: ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газрын Шинжээч Ж.Амгалан /утас: ■■■■■■/;
УИХ-ын Хууль зүй байнгын хорооны зөвлөх Б.Төгсцэнгэл /■■■■■■■■■■/;
Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын шүүгч Б.Батцэрэн (утас: ■■■■■■)
Улсын дээд шүүхийн Иргэний хэргийн танхимын тэргүүн Ч.Баярмаа (утас: ■■■■■■)

Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын тэргүүн Д.Мөнхтуяа /утас: [REDACTED]

Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Л.Энхбилэг / [REDACTED]

Үзэх линк: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17140900562791&showType=1>

<https://legalinfo.mn/mn/detail?lawId=17140997644731&showType=1>

<https://legalinfo.mn/mn/detail?lawId=17141097301741&showType=1>

<https://legalinfo.mn/mn/detail?lawId=17141103154021&showType=1>

<https://legalinfo.mn/mn/detail?lawId=17140817635001&showType=1>

6.Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулах ажилд оролцов.

Засгийн газрын эрх зүйн сургалт, сурталчилгааны бүрэн эрхийн хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025.07.22-ны өдрийн А/20 дугаар тушаалаар Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан бөгөөд Ажлын хэсгээс уг төлөвлөгөөний төслийг боловсруулсан болно. Төлөвлөгөөг Засгийн газрын хуралдаанаар ойрын хугацаанд хэлэлцүүлэхээр хүлээгдэж байна.

Удирдсан албан тушаалтан:

Хууль зүй, дотоод хэргийн сайд асан Л.Мөнхбаатар;

Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар /утас: [REDACTED]

Хамтран ажилласан:

Ажлын хэсгийн Нарийн бичгийн дарга: ХЗДХЯ-ны Сургалт, сурталчилгаа, хөтөлбөрийн хэрэгжилтийн газрын Ахлах шинжээч Г.Болормаа.

Ажлын хэсгийн тушаалыг хавсаргав.

7.Хууль зүй, дотоод хэргийн салбарт Жендэрийн бодлого, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах бодлогыг боловсруулж, батлуулав.

Тус яамны Сургалт, сурталчилгаа, хөтөлбөрийн хэрэгжилтийн газраас хариуцан Хууль зүй, дотоод хэргийн салбарын үйл ажиллагаанд баримтлах Жендэрийн эрх тэгш байдлыг хангах стратеги /2026-2029/, мөн Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах стратеги /2026-2029/-ийг тус тус боловсруулах, батлуулах ажилд оролцсон.

/Тушаалыг хавсаргав/

Хоёр.Засгийн газрын Хэрэг эрхлэх газар-Засгийн газрын референт

Миний бие 2015-2022 онд Монгол Улсын гүйцэтгэх эрх мэдлийн дээд байгууллага болох Засгийн газрын ажлын алба буюу Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газарт Засгийн газрын референтээр ажиллах хугацаанд Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, аймаг, нийслэлийн удирдлага болон бусад төрийн байгууллагатай харилцах асуудал, түүнчлэн бүхий л салбарын хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол, шийдвэр боловсруулах, түүний хэрэгжилтийг хангах ажил үүрэг хашиж, бодлого боловсруулах чиглэлээр мэргэшин ажилласан.

Тухайлбал, энэ хүрээнд 30 гаруй хуулийн төсөл, 700 гаруй тогтоол, шийдвэрийн төслийг бие даан боловсруулах ажлыг хариуцан гүйцэтгэсэнээс онцолбол, Харилцаа холбооны тухай, Шуудангийн тухай, Радио долгионы тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах болон “Олон улсын гэрээнд цахим харилцааг ашиглах тухай” НҮБ-ын конвенц, Дэлхийн шуудан холбооны байгууллагын дүрэм, конвенцид оруулсан нэмэлт, өөрчлөлтийг

соёрхон батлах тухай хуулийн төслүүдийг боловсруулах Ажлын хэсгийн Нарийн бичгийн даргаар ажиллаж, хуулийн төслүүд 2019 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр, 2019 оны 5 дугаар сарын 30-ны өдөр тус тус батлагдсан нь харилцаа холбооны салбарын эрх зүйн орчинг сайжруулах ажилд томоохон дэвшил болсон.

Үзэх линк: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=103542&showType=1>
<https://legalinfo.mn/mn/detail?lawId=103547&showType=1>
<https://legalinfo.mn/mn/detail?lawId=14307>

Мөн Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах Ажлын хэсгийн Нарийн бичгийн дарга, гишүүнээр 2017 оноос эхлэн тус тус ажиллан, улмаар дагалдах 17 хууль тогтоомжийн төслийн хамт эцэслэн боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн нь 2021 оны 7 дугаар сарын 7-ны өдөр батлагдсан болно. Энэхүү хууль нь 1994 онд батлагдсан Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш нийслэлийн хэмжээнд үүсч тулгамдсан маш олон асуудлыг шийдвэрлэх зохицуулалтыг өөртөө агуулснаар чухал ач холбогдолтой болсон.

Түүнчлэн, Улсын Их Хурлаас 2020 онд баталсан Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д бусад хуулийг нийцүүлэх, холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулах ажлыг удирдан зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийн Нарийн бичгийн даргаар ажиллаж, улмаар салбар бүрийн өөрчлөлт оруулах шаардлагатай нийт 127 хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн нь 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр батлагдсан болно. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль болон түүнийг дагалдан батлагдсан эдгээр хуулиуд нь Үндсэн хуулийн хүрээнд орон нутгийн бие даасан байдлыг хангахад томоохон шинэчлэлийн ажил болсон.

Гурав.Барилга, хот байгуулалтын яам- Хуулийн хэлтсийн дарга

Салбарын хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хууль тогтоомжийг боловсронгуй болгох ажлын хүрээнд Газрын багц хуулийн төсөл, Барилгын тухай хуулийн шинэчилсэн найруулга (2016 онд батлагдсан), Хот байгуулалтын тухай, Авто зогсоолын тухай, Хот, тосгоны ногоон байгууламжийн тухай, Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай (2015 онд батлагдсан) зэрэг Монгол Улсын барилга, хот, байгуулалт болон газрын харилцааны салбарын суурь эрх зүйн орчныг сайжруулах, шинээр бий болгох чиглэлээр холбогдох ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллаж байсан.

Дөрөв.Хувийн хэвшилд ажиллах хугацаанд хөдөлмөр, компанийн болон иргэний эрх зүйгээр дагнан мэргэшсэн бөгөөд гадаад худалдааны гэрээ хэлцлүүд дээр ажиллаж байсан туршлагатай. Тухайлбал, Таван богд группээс олон улсын франчайз эрхийн хүрээнд хэрэгжүүлсэн KFC түргэн хоолны сүлжээ рестораны гэрээ хэлцэл болон тус компанийн Дархан-Уул аймагт шинээр хэрэгжүүлсэн гурилын үйлдвэрийн төслийн хүрээнд гадаад улсын хуулийн этгээдтэй байгуулах гэрээ хэлцлүүдийг хариуцан боловсруулж ажиллаж байсан.

4.2 Байгаа бол хэвлүүлсэн бүтээл болон олон нийтэд өгсөн мэдээлэл
-Өөрийн боловсруулсан, хянасан ном, өгүүлэл, тайлан, шийдвэр,

	<p>зөвлөмж зэрэг аливаа хэлбэрээр хэвлүүлсэн материал байгаа бол гарчиг, хэвлэсэн газар, огноог бичнэ.</p> <p>-Өөрийн харьяалагддаг байгууллагын нэрийн өмнөөс бэлдсэн, эсхүл бэлдэхэд оролцсон аливаа хууль тогтоомж, дүрэм, журам, шийдвэр, тайлан, зөвлөмж болон бусад материал байгаа бол түүнийг хэвлэсэн байгууллагын нэр, хаяг, огноо, гол агуулгыг бичнэ.</p> <p>-Сүүлийн таван жилийн хугацаанд хэлэлцүүлсэн лекц, илтгэл, нээлтийн үг зэрэг илтгэл, ярианы товч утга, огноо, газар, танилцах арга замыг бичнэ. Тухайн илтгэл, ярианы хуулбарыг хийх боломжгүй бол түүнийг зохион байгуулсан байгууллагын нэр, хаяг, илтгэл, ярианы огноо, товч утгыг бичнэ.</p> <p>-Сүүлийн таван жилийн хугацаанд хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд өгсөн ярилцлага, нийтлэлийг хамгийн сүүлийнхээс нь эхлэн жагсааж бичнэ. Ярилцлага, нийтлэлүүдийн огноог зааж, боломжтой бол ярилцлагын тэмдэглэл, дүрс бичлэг, нийтлэлийг хуулбарлан өгнө.</p> <p>Жич: Дээр дурдсан материал тус бүрээс нэгийг хавсаргах бөгөөд боломжтой бол цахимаар үзэх цахим холбоосыг тусгана.</p> <p>1.Хүнд ээлтэй, хүртээмжтэй орчин, тэгш оролцооны асуудлаар санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий Ажлын хэсгийн гишүүдэд Хууль зүй, дотоод хэргийн яамны дэргэдэх Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дэд зөвлөлийн үйл ажиллагаа, мөн хууль зүй, дотоод хэргийн салбарт хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах чиглэлээр хэрэгжүүлж буй бодлого, арга хэмжээ, өнөөгийн нөхцөл байдлын талаар танилцуулсан.</p> <p>https://mojha.gov.mn/content/69789af0a34d36733abdbcf1</p>
<p>4.3</p>	<p>Байгаа бол Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл (гэрчилгээ) Хуульчийн мэргэжлийн, эсхүл өмгөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх зэрэг хууль зүйн мэргэжлийн үйл ажиллагааны зөвшөөрөлтэй юу, эсхүл ийм зөвшөөрөлтэй байсан уу /тийм, эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, уг зөвшөөрлийг ямар хугацаанд эзэмшиж байгаа, эсхүл байсан талаараа хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.</p> <p>2015 оноос эхлэн одоог хүртэл Монголын Хуульчдын холбооны гишүүн, хуульч (Гэрчилгээ №4869)</p>
<p>4.4</p>	<p>Байгаа бол магистр ба түүнээс дээш эрдмийн зэрэг цолны талаарх мэдээлэл</p> <p>2024 он, Дотоод хэргийн их сургууль, эрх зүйн магистр (Дипломыг хавсаргав);</p> <p>2009 он, МУИС, Хууль зүйн сургууль, эрх зүйн бакалавр (Дипломыг хавсаргав)</p>
<p>4.5</p>	<p>Сахилгын шийтгэл Сахилгын шийтгэлээр ажлаас халагдаж, эсхүл огцорч байсан уу /тийм, эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.</p> <p>Үгүй</p>

Хавсралт:

Нэр дэвших тухай хүсэлтэд журмын 5.1.1-д заасан дараах баримт бичгийг хавсаргана:

- төрийн албан хаагчийн анкет;
- иргэний үнэмлэхийн хуулбар;
- нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар, эсхүл түүнтэй адилтгах баримт бичиг;
- эрх зүйн бакалаврын, эсхүл түүнээс дээш боловсролын зэргийн дипломын хуулбар;
- хууль зүйн өндөр мэргэшилтэй гэдгийг нотлон харуулсан үйл ажиллагааны талаарх баримт;
- эрх зүйч мэргэжлээр 10-аас доошгүй жил ажилласныг нотлох баримт;
- энэхүү загварт заасан баримт бичиг;
- холбогдох бусад баримт.

Хүсэлт гаргагч:

Эцэг/эхийн нэр: Ганзориг

Өөрийн нэр: Эрдэнэбулган

Гарын үсэг:

Он, сар, өдөр: 2026 оны 05 дугаар сарын 27-ны өдөр

---oOo---